

**БАЙГАЛЬ ДЭЛХИЙГЭЭ  
ХАМГААЛАХАД ГОО  
САЙХНЫ МЭДРЭМЖ**

(Хятадын нэрт зураач Ци Байшигийн  
мэндэлсний 125 жилийн ойд)

Л. ЛХАМДУЛАМ

«Байгаль дэлхий» энэ хоёрхон үгэнд хүний бахархал, бишрэл, гайхал, баяслыг төрүүлэгч хичнээн их зүйл багтнам бэ?

Хүн төрөлхтөн бий болсон цагаасаа хойш далдын аймшигт хүчин мэтээр бишрэн шүтэж байсан «байгаль бурхан»-аа өөрсдийн амьдралын «хэрэглээний баялаг» «аж үйлдвэрийн түүхий эд» болгон хувиргасан эдүгээг хүртэлх түүхийн урт удаан хугацаанд байгалийн гоо сайхныг магтан дуулсан авьяас билэгт хичнээн уран бийртэн төрүүлснийг тоолохын аргагүй юм. Бид тэдний уран гараар бүтсэн үзэмж төгөлдөр уул нуруу, өтгөн ногоон ой мод, эгц өндөр хавцал, өргөн уудам тал нутаг, тунгалаг гол мөрөн ундаргаат булаг шанд, эд бүхнийг чимэх эрээн эрвээхэй, элдэв шавьж, туяхан цэцэгс, улаахан жимсгэнэ зэргийг харахад байгалийн сайхан бүгд нүднээ урган үзэгдэх шиг болдог билээ. Хүрээлэн буй эх байгалийнхаа гоо сайхныг мэдэрч, түүнийг хайрлан хамгаалахыг бүхэнд уриалсан бүтээлүүдээрээ олон түмэнд нэр нь алдаршсан зураачдын нэг нь Хятадын орчин үеийн зургийн өвөг багш — Ци Байши юм.

Ци Байши тэртээ 125 жилийн өмнө (1863 оны 11-р сарын 22-нд) Хунань мужийн Сянтань хэмээх газар нэгэн ядуу тариачны гэр бүлд төржээ. Багын сэргэлэн, цовоо, аливаад ажигч гярхай Эржи\* 3 нас хүрээгүй байхдаа нэрээ бичиж эхэлсэн ба 6 насандаа ханз үсгийг чадмаг бичдэг болжээ. Түүнийг бийр бэхтэй нөхөрлүүлсэн анхны багш өвөө нь байлаа. Ци Байши бүр багаасаа уран зурагт дур сонирхолтой байв. Гэрийнхэн нь Ци Байшиг тариачны хүнд хүчир бял тэнхээ шаардсан ажлаас гарын ур дүй шаардсан ажилд илүү эвсэг болохыг нь анзаарч эхлээд мужаанд дараа нь сийлбэрчинд шавь оруулжээ. Энэ нь түүний уран бүтээлийн замын эхлэл байв. Ци Байшигийн амьдрал бүхэлдээ ялангуяа бага идэр нас маш тарчиг ядуу хүнд нөхцөлд өнгөрчээ. Гэхдээ амьдралын нь хүнд хэцүү байдал уран бүтээлийн их үйлсэд бүхнээ зориулахад нь түүнд огт саад болоогүй билээ. Багаасаа ихэд сонирхдог байсан уран зургийн авьяас билэг гучаад наснаас нь тодорч хавь ойрын нэртэй нөлөө бүхий хүмүүсийн захиасыг биелүүлдэг авьяаслаг зураач гэгдэх болжээ. Гэхдээ Ци Байши урлагийн зөвхөн нэг талыг голлосонгүй. Хятадын үндэсний зураг «го хуа»-г шинэ хэлбэрээр баяжуулахад түүний оруулсан хүчин зүтгэлийг үгүйсгэх аргагүйн адил хичээнгүй бичиг\*, яруу найраг, сийлбэр зэрэг урлагийн бусад төрлийг төгс мэргэш-

\*-Эржи —Гэрийнхэн нь Ци Байшиг багад нь өхөөрдөн дууддаг байсан нэр. орч. Мөөгөн хүү. Харин хожмоо олон түмэнд алдаршсан Ци Байши нэрийг түүний бага сургуулийн багш өгчээ.

\* Хятадад дүрс бичиг хөгжсөн онцлог байдлаас шалтгаалж хичээнгүй бичиг бие даасан урлагийн нэг төрөл болон хөгжжээ.

сэн гоц авьяасыг мөн шагшин гайхахгүй өнгөрөхийн аргагүй билээ. Хятадын урлаг судлаачдын зарим нь Ци Байшиг яруу найраг, хичээнгүй бичгийн хувьд төгс боловсорсон хүн гэж үзэж байхад нөгөө хэсэг нь түүний зурсан зураг, зорсон сийлбэрийн нарийн ур чадварыг илүү үнэлдэг байна.

Дорнодахины зарим орны дүрслэх урлагт хуйлмал зураг чухал байр эзэлдэг. Хуйлмал зургийн нэг онцлог нь зургийн агуулгыг илэрхийлсэн ч юм уу эсвэл түүнд тохирох шүлгийн мөрүүдийг хичээнгүй бичгийн бичлэгийн олон хэлбэрийг ашиглан шадлан бичдэг явдал юм. Уран сайхны өндөр түвшинд зурж, зурагтаа тохирох яруу хэллэг зохион түүнийгээ хичээнгүй сайхнаар бичнэ гэдэг тэр болгон нэрт зураач ч бие даан хийж чадах зүйл биш ажээ. Ци Байшигийн хувьд энэ эрдмийг гойд эзэмшсэн хосгүй авьяастан байлаа. Үүнийг зөвхөн тухайн хүнд заяасан төрөлхийн авьяас билэгтэй л холбож үзнэ гэдэг бас учир дутагдалтай. Тэрээр ямагт урагшлан тэмүүлж, зорьсондоо хүрэхийн тулд бүхий л бие сэтгэлээ бүрэн зориулж чаддаг байв. Бүр бага насанд нь зураач, уран бүтээлч хүний нэг гол шинж уйгагүй хөдөлмөрч зан Ци Байшид илэрдэг байлаа. Сургуулийн жаал хүү гэртээ ирмэгц үлгэр домгийн сэдвээр эсвэл энд тэнд зурж наасан элдэв дүрсийг хажуугийн хүнд бол бүр залхмаар маш олон дахин зурдаг байжээ. Ци Байши идэр залуудаа Хятадын эртний сонгодог уран зургийн нэвтэрхий толиуд, нэрт зураачдын бүтээлүүдийг ихэд сонирхон судалж, дууриан зурдаг байв. Түүний хувьд хуулбарлан зурна гэдэг бол нэг төрлийн урлаг байлаа. Ци Байши аливааг хуулбарлахдаа яг эх зурагтай ижилсүүлэхийг огт эрмэлздэггүй, гол санааг нь авч цааш нь баяжуулан зурдаг байв. Нэг үгээр хэлэхэд, хуулбарлан зурах талаар түүний ойлголт, баримтлах зарчим нь маш өөр байсан ажээ. Энэ байдал нь зураачид өөрийн гэсэн зураг зурах арга барилаа олж авахад өгүүлж баршгүй тус дөхөм болсон байна. Ци Байшийн нэр хичээнгүй хөдөлмөр, үргэлжид шинийг эрэлхийлэх зан ийнхүү амьдралын нь туршид уран бүтээлийн нь гол мөрдлөг болсоор ирсэн юм. 90 нас шүргэж яваа өвгөн зураачаас түүний бүтээлүүд гайхам үнэмшилтэй энгийн атлаа ур чадвараараа ямагт бусдаас давамгайлдаг нууцыг асуухад «Ер нь зураач хүн нэг өдрийг ч зураг зурахгүйгээр төсөөлж болохгүй. Би өдөр бүр зураг зурдаг. Миний хувьд эцсийн амьсгалаа хураатал зургийн ертөнцөөс хагацаж чадахгүй болов уу» хэмээн хариулжээ,

Манай зураачдын дунд нэрт зураач Ци Байшитай биеэр уулзан учирч, уран бүтээлтэй нь танилцаж явсан хүн цөөнгүй бий. Тэдний нэг БНМАУ ын Ардын зураач, Б. Гомбосүрэнтэй уулзахад 1954 онд манай дүрслэх урлагийн үзэсгэлэн БНХАУ-д ажиллах үеэр нэрт зураач Ци Байшитай анх уулзсан тухайгаа ярьсан юм. Тэрээр, «Дэлхий дахинаа нэр нь түгсэн авьяаслаг зураачтай монголын урлагийн төлөөлөгчид бид Бээжин хотын хуучин галт тэрэгний буудлын ойролцоох эд хогшлоор хомсхон ч

\* — Хятадад уран зургийн талаар эртнээс уламжлагдан ирсэн ном, бүтээлүүд маш их бөгөөд түүний нэг нь XVII—XVIII зууны үеийн алдартай бүтээл — «Зезы юаньхуажуань» (Хижийн үрт цэцэрлэгийн гайхамшигт зураглалаас өгүүлэх нь) юм, Хятадын эртний сонгодог уран зургийн гайхамшиг хэмээн алдаршсан уг нэвтэрхий толь нь дараа дараагийн үеийн, зөвхөн Хятадын төдийгүй, Япон, Солонгос зэрэг орны зураачдын үнэт гарын авлага, эх материал болсоор иржээ. Хорхой шавьж, өвс ургамал, цэцэгсийг хэрхэн зурах талаар маш тодорхой өгүүлж түүндээ эртний нэрт мастеруудын зурсан зургуудыг хавсаргасан уг ном нь 2000 гаруй хуудастай ажээ.

зураг, будаг, бийрээр дүүрэн өрөөнд нь нүүр учрах завшаан олдсонсон. Ерээд настай гэхэд маш хөнгөн шалмаг Ци Байши гуай бидэнд зураг зурж үзүүлэхэд түүний гоц авьяасыг бахдахаас өөр аргагүй байлаа. Маш дадмаг түргэн хөдөлгөөнөөр бийрийнхээ будгийг юу ч үлдээлгүй хэд хэд татаж, энд тэнд цэглэх шиг болсны дараа зургийг үзэхэд тийм өндөр настай хүн, нэг хоёр бийрээр хурам төдий зурсан гэхэд итгэмээргүй нарийн ур чадварыг илтгэсэн зураг нүднээ тусч байсансан» хэмээн дурсан ярьсан билээ.

Ци Байшигийн уран бүтээлийн дэвжилтэд эх орныхоо байгалийн үзэсгэлэнт газруудаар 8 жилийн турш хийсэн хэд хэдэн удаагийн аялал маш их үүрэг гүйцэтгэсэн байна. Зураачийн зурсан «Хуашань уул», Гуйлины үзэсгэлэнт байгалийг харуулсан цуврал», Шимэний байгалийн 24 зураглал», «Мандаж буй нар», «Тайшань уулан дахь сүм» зэрэг бусад олон бүтээлүүд бүгд л түүний 10 мянган ли зам аялан туулсны дараа зүрх сэтгэлээр нь дамжин, уран гараар нь бүтсэн их хөдөлмөрийн үр дүн байлаа.

БНХАУ-ын Ардын зураач, Бүх Хятадын зураачдын нийгэмлэгийн дарга агсан нэрт зураач Ци Байши амьдрал уран бүтээлийн их замыг туулж 96 наслахдаа хэдэн мянган бүтээл туурвисны 400 орчмыг нь насан өөд болохынхоо өмнөх багахан хугацаанд хийсэн байна.

Өнөө үед байгаль дэлхийгээ хамгаалах асуудал ялангуяа хүмүүст экологийн хүмүүжил олгох асуудал хүн төрөлхтний өмнө хурцаар тавигдаж байна. Байгаль орчинтойгоо хайр гамгүй харьцах, түүнийг тонон сүйтгэж байгаа явдал эцэстээ биднийг идэх хоолноос маань салгаад зогсохгүй амьсгалах агааргүй ч болгож болзошгүй байгааг хүмүүст ухааруулан ойлгуулахад яруу урлаг, түүний дотор уран зураг чухал үүрэг гүйцэтгэх ёстой.

Өөрийн уран бүтээлдээ «Гоо сайхны мэдрэхүй нь байгаль дэлхийг аварна» гэсэн үзлийг чанд баримталж ирсэн Хятадын нэрт зурагч Ци Байши гэрэлт ертөнцөд хүн болж төрсөн өөрийн үүргийг гүнээ ухамсарлаж түүндээ үнэнчээр зүтгэхийн үлгэр дууриаллыг ард түмэн хойч үедээ үзүүлж чадсан юм. Хятадын «го хуа» үндэсний зургийн их мастер Пань Тяньшоу, уран зургийн ертөнцөд амьдралынхаа утга учир, цуцалтгүй хөдөлмөр, оюун билэг юугаан зориулсан Ци Байшийн уран бүтээлийн бүх хүн төрөлхтний урын санд оруулсан ач холбогдлыг үнэлэн, «Хүн төрөлхтөнд энх тайван, гэрэлт нар, эх дэлхийн давтагдашгүй гоо сайхан хэрэгтэй байгаа цагт бидэнд Ци Байши хэрэгтэй» хэмээн хэлсэн нь жирийн үг биш ээ.